



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

Гадаадын зээл, тусламжийн бодит хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэй төлөвлөөгүй, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцохгүй байна

Аудитын сэдэв: Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

Аудитын код: ГНАГ-2025/22-ШТА-ГА

Аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд
Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Б.Сандуйжав
Утас: 261639, Цахим хаяг: sanduijavb@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Энх-Амгалан
Цахим хаяг: enkhamgalankh@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Бумдарь
Цахим хаяг: bumdarich@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Мөнхцэцэг
Цахим хаяг: munkhtsetsegb@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Чинбат
Цахим хаяг: chinbatj@audit.gov.mn

Аудитор С.Номин-Эрдэнэ
Цахим хаяг: nomin-erdenes@audit.gov.mn

Аудитор А.Төгөлдөр
Цахим хаяг: tuguldura@audit.gov.mn

Аудитор А.Учрал
Цахим хаяг: uchrala@audit.gov.mn

Аудитор Б.Лхагвасүрэн
Цахим хаяг: lkhaqvasurenb@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллагууд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Г.Занданшатар), Төсвийн ерөнхийлөн захирагч нар, Нийслэлийн Засаг дарга (Х.Нямбаатар)-д тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т тус тус даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.


6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Б.Мөнхдөл)-д даалгасугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\1222 GAG-1.Docx

1525010149



“Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

/сая.төгрөг/

№	Зөрчил хариуцах		Мөнгөн дүн	Товч утга
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Төрийн нарийн бичгийн дарга	443.3	Төслийн нэгж албан томилолтын хуваарийг батлаагүй, тухайн жилийн төсвийг хэтрүүлэн зарцуулсан.
2	Эрчим хүчний яам	Төрийн нарийн бичгийн дарга	-	Өрийн удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн тооцоолол, эрсдэлийн үнэлэгээ хийгдээгүй, захиалагчид батлагдсан ажлын зурагийн эх хувь ирүүлээгүй.
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Сайд	-	Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-д заасны дагуу харьяалах тусламжийн хөтөлбөрийг бүрэн бүртгээгүй, аудитын гүйцэтгэлийн шатанд шаардлагатай мэдээллийг гарган өгөөгүй сахилгын шийтгэл ноогдуулах.
4	Боловсролын яам	Төрийн нарийн бичгийн дарга	-	Тусламжийн санхүүжилтээр баригдсан 3 сургуулийг улсын комисс хүлээн аваагүй байхад ашиглалтад оруулсан.
5	Сангийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	-	Төслийн хэрэгжилт удааширсан, барилга, байгууламж ашиглалтад ороогүй.
		Төрийн нарийн бичгийн дарга	-	Төслийн хэрэгжилт удааширсан, барилга, байгууламж ашиглалтад ороогүй.
6	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Төрийн нарийн бичгийн дарга	4,399.4	Зарим байгууламжийн технологийн горим батлаагүйгээс ашиглаагүй
		Төрийн нарийн бичгийн дарга	22,062.3	Зээлийн хөрөнгөөр барьсан барилга, байгууламжийг ашиглаагүй.
		Төрийн нарийн бичгийн дарга	39,570.0	Төслийн хэрэгжилт удааширсан, барилга, байгууламж ашиглалтад ороогүй.
Нийт			66,475.0	

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт.....	3
Хавсралтын жагсаалт.....	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилго.....	4
Аудитын хамарсан хүрээ.....	4
Аудитын арга зүй.....	4
Аудитын шалгуур үзүүлэлт	4
Аудитын багийн бүрэлдэхүүн.....	5
БҮЛЭГ 1. Гадаад зээл, тусламжийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэй тодорхойлоогүй байна.	11
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр нөлөө бодитой тооцоо, судалгаанд үндэслэн баталгаажгаагүй байна.....	11
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна.....	12
БҮЛЭГ 2. Гадаад зээлийн эх үүсвэрийг хугацаанд нь үр ашигтай ашиглах үйл явц хангалтгүй байна.	14
Гадаад зээл, тусламжаар санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүн хангалтгүй, хугацаа сунгасан байна.	14
Гадаад зээл, тусламжийн үр дүнд нийгэм, эдийн засагт эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байна	22
ДҮГНЭЛТ	27
ЗӨВЛӨМЖ.....	28
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	30
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР.....	33

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах ажил
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц улс
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
АДБХОБ	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк
БНПУ	Бүгд Найрамдах Польш улс
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
СаЯ	Сангийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ЭЗХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БоЯ	Боловсролын яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИНЕГ	Иргэний нисэхийг ерөнхий газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
МСК	Мянганы Сорилтын Корпорац
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
ЭБЦТС	Эрдэнэд Булганы цахилгаан түгээх сүлжээ
БЗӨБЦТС	Баруун зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан гадаад зээл, буцалтгүй тусламж	7
Хүснэгт 2	Монголын талын хөрөнгө оруулалт хийгдсэн төслүүд	8
Хүснэгт 3	Засгийн газрын өрийн үлдэгдэл	9
Хүснэгт 4	ТЕЗ-чид болон СаЯ-ны мэдээллийн зөрүү	9
Хүснэгт 5	Гадаад зээл, тусламжийн ашиглалт	14
Хүснэгт 6	Зээлийн ашиглалтад үзүүлж буй зөвлөх үйлчилгээний зардал	14
Хүснэгт 7	Хугацаа сунгасан төслийн мэдээлэл	16
Хүснэгт 8	Зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл	24
Хүснэгт 9	Нийт гадаад зээлийн эргэн төлөлт, ханшийн зөрүү	25
Хүснэгт 10	Гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын харьцаа	25

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Нийт зээл ашиглалт	8
Дүрслэл 2	Салбарын мэдээлэл	14
Дүрслэл 3	Зардлын харьцааны хувь	15
Дүрслэл 4	Төслүүдийн явцын мэдээлэл	16
Дүрслэл 5	Нийт ажлын гүйцэтгэлийн дундаж хувь	16

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	ТАХ-ний хөгжлийн бодлого, зорилготой уялдсан байдал
Хавсралт 2	Гэрээ хэлэлцээр нь хийгдэж, Улсын Их Хурлаас соёрхон баталсан гадаадын зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл
Хавсралт 3	Төсөл, арга хэмжээний зураг

Аудитын зорилго, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн аудитыг хийлээ.

Аудитын зорилго

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг хэрэгцээ, шаардлага, үндэслэлтэйгээр авсан эсэх, түүнийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төлөвлөсөн зорилгодоо хүрч, эдийн засагт бодит үр нөлөө үзүүлж чадсан эсэхийг үнэлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Гадаад зээл, тусламж авах хэрэгцээ, шаардлага, үндэслэл тодорхой байсан эсэх;
- Гадаад зээл, тусламжийг үр дүнтэй ашигласан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Засгийн газрын гадаад зээл¹, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв болон холбогдох байгууллага, төслийн нэгж, гүйцэтгэгчийг хамруулж төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн тайлан, мэдээ, судалгаа, гаргасан шийдвэрүүд болон бусад баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Хугацааны хувьд 2021-2025 оны хамруулсан бөгөөд зээлийн эргэн төлөлт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээс шалтгаалж зарим үзүүлэлтэд өмнөх онуудыг хамруулсан болно.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

Хуулиуд:

- Төсвийн тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж.

Журмууд:

¹ Засгийн газрын гадаадын зээлийн хувьд аудитын хугацаа, хүний нөөцөөс шалтгаалж хөтөлбөрийн зээлийг хамруулаагүй болно.

- Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журам (Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 66 дугаар тогтоолын хавсралт);
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам (Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралт);
- Гадаад тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам (Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан);
- Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам (Засгийн газрын 2021 оны 211 дүгээр тогтоол);
- Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, төвлөрүүлэх, өр төлбөрийг бүртгэх тайлагнах журам (Сангийн сайдын 2015 оны 11 сарын 02-ны өдрийн 300 дугаар тушаал);
- Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам (Засгийн газрын 2022 оны 201 дугаар тогтоол);
- Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам (Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоол).

Дараах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

Бодлогын баримт бичгүүд:

- Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт);
- Шинэ сэргэлтийн бодлого (УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт);
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр (УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт);
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралт)
- Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024 оны төлөвлөгөө (Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын хавсралт)
- Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг (Монгол Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолын хавсралт);
- Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг (Монгол Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолын хавсралт);
- Засгийн газрын зээллэгийн 2021-2025 оны төлөвлөгөө;
- Сангийн яамны стратеги төлөвлөгөө 2022-2024.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Б.Сандуйжав үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Энх-Амгалан, Ж.Чинбат, Ч.Бумдарь, Б.Мөнхцэцэг, аудитор С.Номин-Эрдэнэ, А.Төгөлдөр, А.Учрал, Б.Лхагвасүрэн нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын хүндрэл бэрхшээл

Аудитын үйл ажиллагааг гүйцэтгэх хугацаа харьцангуй богино байсан нь шаардлагатай мэдээллийг бүрэн цуглуулах, баталгаажуулах боломжийг хязгаарласан, Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн төслүүдийн нэгдсэн тоо, мэдээлэл нь холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргаж буй мэдээлэлтэй хоорондоо зөрүүтэй байсан зэрэг нь аудитын багийн ажилд хүндрэл учруулсан бөгөөд БОУАӨЯ аудитад шаардлагатай баримт, материалыг бүрэн гаргаж өгөөгүйгээс зарим судалгаа, тоо мэдээнд² хязгаарлалт хийхэд хүргэсэн болно. Мөн дамжуулан зээлийн мэдээлэл ТЕЗ нарт үнэн зөв, бүрэн байгаагүй тул энэ зээлийн мэдээлэлд хязгаарлалт хийж 2021 оноос хэрэгжүүлсэн 3 ТАХ-г хамруулсан болно.

Аудитын материаллаг илрүүлэлт

Аудитаар илэрсэн 66,500.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, холбогдох бусад зөрчилд зөвлөмж өгсөн.

² Тус яамны гадаадын тусламжтай холбоотой мэдээлэл судалгаанд хамрагдаагүй болно. Мөн гадаадын зээлийн мэдээлэлд аудитын явцад тулгалт хийсэн 1 арга хэмжээнээс бусад нь хамрагдаагүй.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улс Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дэх хэсэгт 7 төрлийн зориулалтаар өр үүсгэж болно гэж зааснаас тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т “Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх”, 12.1.5-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх” заалтуудыг тус тус үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

Монгол Улс 2008–2025 онд 116 гадаад зээлийн гэрээ байгуулж, нийт 5,329.9 сая ам.доллар (24,033.8 тэрбум төгрөг)-ын зээлийн санхүүжилтийг татан ашиглаж байна. Мөн энэ хугацаанд буцалтгүй тусламжийн 42 гэрээ байгуулж, нийт 551.5 сая ам.доллар буюу 3,144.3 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийг олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас хүлээн авч, холбогдох төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд зарцуулж байна. Нийт гадаад зээлийн 18.1 хувь буюу 21 зээлийн төсөлд 2,036.7 тэрбум төгрөгийн дотоодод дамжуулан зээл олгосон байна.

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан нийт гадаад зээлийн 81.0 хувь буюу 19,376.3 тэрбум төгрөгийг АХБ, БНЭУ, БНХАУ, БНСУ, Дэлхийн банкнаас, нийт буцалтгүй тусламжийн 83.0 хувь буюу 2,606.5 тэрбум төгрөгийг АНУ, БНХАУ, АХБ-аас авч ашиглажээ.

Хүснэгт 1. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан гадаад зээл, буцалтгүй тусламж /сая төгрөг/

№	Санхүүжүүлэгч байгууллага	Гадаад зээл			Буцалтгүй тусламж		
		Нийт төсөл	Зээлийн дүн	Хувь	Нийт төсөл	Зээлийн дүн	Хувь
1	Кувейт	-	-	0%	2	41,252.1	1%
2	Австри	10	331,595.2	1%	-	-	0%
3	АДБХОБ	1	75,329.9	0%	-	-	0%
4	АНУ	-	-	0%	1	1,255,499.0	40%
5	АХБ	45	6,210,376.0	26%	18	502,266.2	16%
6	БНПУ	3	167,870.1	1%	-	-	0%
7	БНСУ	9	2,296,028.0	10%	-	-	0%
8	БНФУ	5	689,382.8	3%	-	-	0%
9	БНХАУ	9	2,585,525.0	11%	5	848,767.6	27%
10	БНЭУ	2	6,163,424.0	26%	-	-	0%
11	Боловсролын дэлхийн түншлэл	-	-	0%	1	17,935.7	1%
12	ДБ	17	2,120,994.0	9%	4	65,771.1	2%
13	ЕСБХБ	7	1,108,907.0	5%	6	152,449.9	5%
14	ЕХОБ	3	397,006.7	2%	1	37,665.0	1%
15	Люксембург	-	-	0%	2	55,293.5	2%
16	ХБНГУ	2	113,778.6	0%	2	177,403.4	6%
17	Япон	3	1,763,524.0	7%	-	-	0%
Нийт дүн		116	24,033,784.1	100%	42	3,144,259.0	100%

Эх сурвалж: Аудитын тооцоолол

Нийт 21 гадаадын зээл, буцалтгүй тусламжийн гэрээний хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдэд Монголын тал нийт 824.5 тэрбум төгрөгийн хамтран санхүүжилт бүрдүүлэн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хүснэгт 2. Монголын талын хөрөнгө оруулалт хийгдсэн төслүүд

³12.1. Засгийн газар дараах зориулалтаар өр үүсгэж болно:

12.1.1. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх.

12.1.2. төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх.

12.1.3. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих.

12.1.4. Өрийг дахин санхүүжүүлэх.

12.1.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх.

12.1.6. Улсын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.


12.1.7. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэх

№	ТЕЗ	Евро /ханш нь 4134.96/		Иен /ханш нь 22.93/		Төгрөг/сая/		Ам.доллар / ханш нь 3587.14/		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БОУАӨЯ	2	11.9	-	-	-	-	-	-	2	11.9
2	БоЯ	-	-	-	-	1	0.06	-	-	1	0.06
3	ЗТЯ	-	-	2	1,505.8	1	1,162.8	-	-	3	2,668.6
4	НЗДТГ	-	-	-	-	2	12,102.5	4	35.0	6	12,137.5
5	СаЯ	-	-	-	-	1	54,290.7	1	111.7	2	54,402.4
6	ХББОСЯ	1	2.5	-	-	2	57,001.9	-	-	3	57,004.4
7	ЦХИХХЯ	-	-	-	-	1	3,945.9	-	-	1	3,945.9
8	ЭМЯ	-	-	-	-	1	18,617.1	-	-	1	18,617.1
9	ЭХЯ	-	-	-	-	2	57,081.7	-	-	2	57,081.7
Нийт		3	14.4	2	1,505.8	11	204,202.7	5	146.7	21	205,869.7

Эх сурвалж: Аудитын тооцоолол

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас 2025 оны 12 сарын байдлаар 3,830.7 сая ам доллар буюу 11,085.2 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, ашигласан байна.

Дүрслэл 1. Нийт зээлийн ашиглалт /2020-2025 он/



Нийт гадаад зээлийн ашиглалтыг жилийн байдлаар авч үзвэл 2020 онд 14.83%-тай байсан бол 2021 онд 11.76% болж буурсан байна. Харин 2022 онд ашиглалт 17.19% болж өссөн бөгөөд энэ өсөлт 2023 онд 16.12%-ийн түвшинд хадгалагдсан байна. 2024 онд нийт зээлийн ашиглалт 27.46% хүрч хамгийн өндөр түвшинд хүрсэн нь судлагдсан хугацаанд хамгийн их өсөлттэй жил болсон нь харагдаж байна. Харин 2025 онд ашиглалт 12.65% болж, өмнөх оныхоос эрс буурсан үзүүлэлттэй байна.

Нийт гадаад зээл, буцалтгүй тусламжийн 40.5 хувийг дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн салбар 58.2 хувь, үйлдвэрлэлийн салбарт 1.3 хувийг тус тус зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2021 онд нийт өрийн 91.7 хувийг, 2022 онд 92.7 хувийг, 2023 онд 98.4 хувийг, 2024 онд 95.8 эзэлж, жилээс жилд нэмэгдсээр байна.

Энэхүү өсөлт нь гадаад эх үүсвэртэй санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө их байснаас гадна дотоодын үнэт цаасны арилжааг хумих, зарим үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авч дотоод өрийн үлдэгдлийг бууруулсан бодлогын шийдвэрүүдтэй шууд холбоотой байна.

Хүснэгт 3. Засгийн газрын өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2021 оны 4-р улирал	2022 оны 4-р улирал	2023 оны 4-р улирал	2024 оны 4-р улирал	2025 оны эхний хагас жил
Засгийн газрын нийт өр	26,918.2	31,964.8	30,773.6	33,399.9	35,533.5

Засгийн газрын дотоод өр	674.5	1,047.8	238.6	1,200.4	1,262.5
Үнэт цаас	674.5	1,047.8	238.6	1,200.4	1,262.5
Засгийн газрын гадаад өр	24,693.3	29,641.6	30,274.6	32,021.5	34,094.8
Үнэт цаас	8,175.6	9,359.8	9,371.7	10,379.9	10,929.4
Гадаад зээл	16,517.7	20,281.8	20,902.9	21,641.6	23,165.4
Засгийн газрын өрийн баталгаа	876.5	811.8	29.5	178.0	176.2
Барих-шилжүүлэх төрлийн концесс	673.9	463.5	230.9	-	-

Эх сурвалж: <https://www.1212.mn/mn>

Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 2022 онд 2021 оноос ойролцоогоор 19.9 хувиар өсөж, 2023 онд өсөлт нь 3.8 хувьтай байсан бол 2024 онд дахин 6.4 хувиар нэмэгдсэн байна.

Тодруулга:

Аудитын явцад 18 ТЕЗ-аас гадаад зээл, тусламжийн мэдээлэл, судалгаа авч СаЯ-ны мэдээлэлтэй тулгахад зөрүүтэй байсан болно. Харьцуулан харуулбал:

Хүснэгт 4: ТЕЗ-чид болон СаЯ-ны мэдээллийн зөрүү /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ		Аудитын судалгааны нэгтгэл	Сангийн яамны мэдээлэл	Зөрүүтэй эсэх	Зөрүү	
					мөнгөн дүн	тоо
Санхүүжилт	Төслийн тоо	143	158	✓		(15.0)
	Зээлийн гэрээний дүн	15,176.9	24,033.7	✓	(8,856.8)	
	Тусламжийн гэрээний дүн	2,639.8	3,144.2	✓	(504.4)	
	Техник туслалцаа гэрээний дүн	32.7	57.1	✓	(24.4)	
	Монгол талын хөрөнгө	2,024.4	205.8	✓	1,818.6	
Ашиглалт	Зээлийн ашиглалт	12,874.8	11,085.2	✓	1,789.6	
	Дамжуулан зээлийн дүн	6,498.2	2,036.6	✓	4,461.6	
	Гүйцэтгэлийн хувь	80.8%	70.0%	✓		10.8%
Хэрэгжилтийн төлөв	Хэрэгжиж байгаа	78	84	✓		(6)
	Хэрэгжиж дууссан	61	74	✓		(13)
	Хэрэгжиж эхлээгүй	8	0	✓		8
Зээлийн эргэн төлөлт	Үндсэн зээл	-	160.8	✓	(160.8)	
	Нийт дүн	-	262.5	✓	(262.5)	
Санхүүжүүлэгч байгууллага	Зээл	99	116	✓		(17)
	Буцалтгүй тусламж	44	42	✓		2
Зээл төлөх эх үүсвэр	Улсын төсөв	98	114	✓		(16)
	Буцалтгүй тусламж	42	41	✓		1

Эх сурвалж: Сангийн яам, аудиторын тооцоолол

Дээрх мэдээллээс харахад ТЕЗ-даас авсан мэдээллийн хүрээнд гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй ТАХ-ний тоон мэдээлэл 143 харин СаЯ-ны мэдээлэл 158 ба холбоотой бусад мэдээлэл бүгд зөрүүтэй байна. Энэ нь ТЕЗ нар тухайн салбарт хэрэгжиж буй

ТАХ-ний нэгдсэн мэдээллийг бүрэн бүртгэдэггүй, хоорондын уялдаа холбоо хангалтгүй, гадаад зээл, тусламжийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүйг харуулж байна.

Иймд СаЯ-нд бүртгэлтэй 158 ТАХ-ний хүрээнд аудитыг гүйцэтгэсэн болно.

БҮЛЭГ 1. Гадаад зээл, тусламжийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэй тодорхойлоогүй байна.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр нөлөө бодитой тооцоо, судалгаанд үндэслэн баталгаажуулж байна

1.1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2021-2025 онд шинээр хэрэгжүүлж байгаа 55 төсөл, арга хэмжээ нь улсын хөгжлийн бодлого, зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Гадаадын зээл

Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр 2021 оноос хойш хэрэгжүүлж буй 38 ТАХ нь улсын хөгжлийн урт, дунд, хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн байна. Харин 10 ТАХ нь богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөөнд, 24 ТАХ нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй байна.

Гадаадын тусламж

Гадаадын тусламжийн хөрөнгөөр 2021 оноос хойш хэрэгжүүлж буй 17 ТАХ нь улсын хөгжлийн урт, дунд, хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн байна. Харин 14 ТАХ нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй байна.

1.2. Дээрх мэдээллээс харахад гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдаагүй зөрчил байсаар байна. Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3⁴, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4.1.1⁵-д заасан шаардлагыг хангаагүй байна. Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу.

1.3. Энэ шаардлагаас гадна тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4⁶, 18.5.7⁷-д заасан шаардлагыг Засгийн газрын шинээр хийх зээллэг хангаж байгаа эсэхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санал, дүгнэлт гаргахаар заасан⁸ ч уг санал, дүгнэлтийг огт гаргаагүй байна. Уг асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.4. СаЯ-аас ТАХ-г хууль, журмын шаардлага хангасан эсэхийг хянаж санал, дүгнэлт гаргах ажлыг “Танилцуулга” хэлбэрээр бэлтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж байна.

1.5. Тус танилцуулгад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн мэдээлэл, төсөвт өртөг /зээлийн дүн/, бодлогын баримт бичигт туссан эсэх, тухайн оны Төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдлыг тусгаж байна. Энэ нь хуульд заасан шаардлагыг хангахгүй байна.

1.6. Одоогийн байдлаар шинээр зээлийн хэлэлцээр хийгдэж байгаа төслүүдэд хуульд заасан санал, дүгнэлт гаргах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.7. Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ нь нийгэм, эдийн засгийн үр нөлөөтэй, эрэмбэлсэн байхаар хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна.

Хууль тогтоомж	Мөрдөж эхэлсэн хугацаа	ТАХ-ний шалгуурыг хангасан байдал
----------------	------------------------	-----------------------------------

⁴ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байх

⁵ Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх

⁶ тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх

⁷ тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж, баталгаажуулсан байх

⁸ Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6

Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.8. “Эдийн засгийн бодит үр өгөөж өгөх ТАХ байх нь холбогдох тооцоо, судалгаагаар нотлогдсон байх”	2023.07.07	Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр 2024 оноос хойш хэрэгжүүлж байгаа 13 ТАХ эдийн засгийн бодит үр өгөөж өгөх нь тооцоо, судалгаагаар нотлогдсон талаарх баримт холбогдох байгууллагуудад байхгүй байна.
Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.5. “гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлж байгаа тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ эдийн засгийн үр ашигтай, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон байх”	Хуулийг дагаж мөрдсөн хугацаа	Гадаад зээллэгийн хөрөнгөөр 2021 оноос хойш хэрэгжүүлж буй 3 ТАХ-нд уг үнэлгээг хийгээгүй байна.
Сангийн сайдын 2021 оны 4-р тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 6.4.1. “төсөл, арга хэмжээний саналыг хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, зээл, тусламжийн нэгдсэн бодлоготой уялдуулан ач холбогдол, хэрэгжих боломжоор нь эрэмбэлэх, нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, үр өгөөжийн үнэлгээг хийлгэх, төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлохоор эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, холбогдох санал, дүгнэлтийг авах”	2024.01.23	ЭЗХЯ-аас энэ хугацаанд 7 ТАХ-ний санал, дүгнэлтийг СаЯ-нд хүргүүлсэн ба 4 ТАХ-ний санал, дүгнэлт нь Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр 2024 оноос хойш хэрэгжүүлж байгаа 13 ТАХ-х биш байна. Тодруулбал: Эдгээр 13 ТАХ-ээс 10 нь санал, дүгнэлт гараагүй байна. Нөгөө талаар ЭЗХЯ-аас СаЯ-нд хүргүүлсэн 7 санал, дүгнэлт нь бодитой тооцоо, судалгаанд үндэслэж нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, үр өгөөжийг үнэлсэн нь нотлогдохгүй байна.
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна		
1.8. Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх ТАХ нь хөгжлийн бодлого төлөвлөлттэй нийцсэн, эдийн засгийн үр ашигтай байх гэсэн шалгуураас гадна дараах шаардлагыг хангасан байхаар хууль тогтоомжид тусгасан байна. Үүнд:		
Өрийн удирдлагын тухай хууль /18 дугаар зүйлийн 18.5/	Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам Журмын 6.2	
Төсөвт тусгагдсан байх, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх, Тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх,	ТАХ хэрэгжүүлэх үндэслэл, эрх зүйн орчин, салбарын бодлого, зохицуулалт, хэрэгцээ шаардлага, зорилго, хамрах хүрээ, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, хугацаа, байршил, үр шимийг хүртэх этгээд, Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа ижил төстэй төсөл, арга хэмжээ болон санал болгож байгаа төсөл, арга хэмжээний уялдаа холбоо, ялгагдах байдал, тухайн хөгжлийн түншид санал болгох үндэслэл,	

ТАХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгийн тооцоо, үүнд гадаад зээл болон дотоод эх үүсвэрийг хамруулна,

ТАХ хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, санхүү, хүний нөөцийн чадавх,

Гадаад зээлийг эргэн төлөх эх үүсвэрийн санал,

ТАХ-ний эрсдэлийн үнэлгээ,

ТАХ хэрэгжиж дууссаны дараах үйл ажиллагаатай холбоотой төлөвлөлт

1.9. Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр 2021 оноос хойш хэрэгжүүлж буй 38 ТАХ нь дээрх хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан эсэхийг тодорхойлсон баримт холбогдох байгууллагад байхгүй байна.

1.10. Эдгээр нөхцөл байдал нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлага, бодит үр нөлөөг бодитой тооцоо, судалгаанд үндэслэж төлөвлөдөггүйг харуулж байна.

1.11. Засгийн газар гадаад зээллэг хийхдээ хуульд заасан дээрх шаардлагыг хангаагүй төсөлд зээлийн хэлэлцээр хийж, гэрээ байгуулж тухайн төслийг хэрэгжүүлж байгаа нь төслийн хэрэгжилт удааширах нөхцлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

- Төсөл хэрэгжиж эхлэх үед зураг, төсөв, ТЭЗҮ-г боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаа 0-6 сар, зураг төсөв боловсруулж батлуулах хугацаа 3-12 сар, тухайн барилга байгууламжийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаа 2-5 сарын хугацааг зарцуулж байна. Өөрөөр хэлбэл дээрх үйл явцад дунджаар 1 жил 6 сарыг зарцуулж байна. Энэ нь зарим тохиолдолд зээлдүүлэгчийн шаардлагын дагуу бэлтгэл ажлыг дахин хангах нөхцөл байдал үүсдэгтэй холбоотой байна.

БҮЛЭГ 2. Гадаад зээлийн эх үүсвэрийг хугацаанд нь үр ашигтай ашиглах үйл явц хангалтгүй байна.

Гадаад зээл, тусламжаар санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүн хангалтгүй, хугацаа сунгасан байна.

2.1. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2008–2025 оны хооронд нийт 158 ТАХ хэрэгжиж байгаагаас салбараар ангилан харуулбал:

Дүрслэл 2: Салбарын мэдээлэл /сая төгрөг/



Энэ үзүүлэлтээс харахад гадаадын зээл, тусламжийг дэд бүтцийн салбарт түлхүү чиглүүлж гэрээ байгуулсан байна.

Эх сурвалж: Сангийн яам

2.2. Гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтын мэдээллийг харуулбал:

Хүснэгт 5: Гадаад зээл, тусламжийн ашиглалт /сая төгрөг/

Гадаад зээл, тусламжийн гэрээний дүн		Гадаад зээл, тусламжийн ашиглалт	
Зээл	Тусламж	Зээл	Тусламж
24,033,784.1	3,144,259.0	9,509,413.6	1,575,800.8

Нийт зээлийн 39.5 хувийг ашигласан байна.

Эх сурвалж: Сангийн яам

2.3. Өрийн удирдлагын тухай хуулийн шалгуурыг хангаагүй ТАХ санхүүжүүлснээр 5 ТЕЗ-ийн 18 ТАХ-ыг хэрэгжүүлэхдээ 121 удаагийн зөвлөх үйлчилгээний гэрээгээр нийт 420.5 тэрбум төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулснаас 193.4 тэрбум төгрөг нь техникийн хяналтын зөвлөх үйлчилгээ, 227.0 тэрбум төгрөг нь байгаль орчны үнэлгээний тайлан, ажлын зураг, эдийн засгийн судалгааны баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээнд зарцуулсан байна. Зөвлөх үйлчилгээний зардлыг нийт зээлийн дүнтэй харьцуулан харуулбал:

Хүснэгт 6: Зээлийн ашиглалтад үзүүлж буй зөвлөх үйлчилгээний зардал /сая төгрөг/

ТЕЗ	Нийт зээлийн ашиглалт	Зөвлөх үйлчилгээний зардал	Зээлийн ашиглалтад эзлэх хувь
БОУАӨЯ	79,943.6	19,668.7	25%
ГБХНХЯ	473,761.5	2,910.1	1%
ЗТЯ	2,497,175.0	41,438.5	2%
ССАЖЗЯ	54,413.0	9,158.1	17%
ЭХЯ	1,331,283.5	153,868.1	12%
Нийт дүн	4,904,831.6	227,043.5	5%

Энэ үзүүлэлтээс харахад БОУАӨЯ, ССАЖЗЯ зөвлөх үйлчилгээ түлхүү авсан байна

Эх сурвалж:

**Хөрөнгө
баталгаажуулсны
хураамж**


Гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 2025 оны байдлаар **14.7** их наяд төгрөг байна. Ашиглагдаагүй үлдэгдэлд 2021 –

2025 оны хооронд нийт **121.5** тэрбум төгрөгийн хөрөнгө баталгаажуулсны хураамж төлсөн байна.

2.4. Засгийн газрын шугамаар гэрээ хэлэлцээр нь байгуулагдаж, УИХ-аас соёрхон баталсан гадаад зээлийг бүрэн ашиглахгүй нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал 2025 оны байдлаар нийт 89 төслийн 14.7 их наяд төгрөгийн зээлийг ашиглаагүй байна. Дэлгэрэнгүйг хавсралт №2-оос харна уу.

2.5. Энэ нь Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх урсгал зардлын дүн нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд эдийн засгийн бодит салбарын өсөлтийг бий болгох зардлын хэмжээг бууруулах эрсдэлтэй байна. Зардлын дүнг харьцуулан харуулбал:

Дүрслэл 3: Зардлын харьцааны хувь



Эх сурвалж: Сангийн яам

2.6. Дээрх мэдээллээс харахад эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд эзлэх хувь тогтмол байна.

2.7. Эдгээр 89 төслийн 95.5 хувийн гэрээний хугацаа 2030 онд дуусах бөгөөд зээлийн ашиглалтын хэмжээ хангалтгүй байгаагаас төслүүдийн хэрэгжилт удааширч, үнэ өсөх, хүлээгдэж буй үр дүн гарахгүй болж, ямар нэгэн бодлогын өөрчлөлт хийхгүй тохиолдолд төслүүд 10 гаруй жил хэрэгжих эрсдэл бодитоор бий болсон байна.

Зориулалт бус зарцуулалт

2.8. Зарим төслийн зардлаас зориулалт бус зарцуулсан тохиолдол гарсан байна. Тухайлбал:

- *БОУАӨЯ, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл II, III шат:*

Уг төслийн зардлаас 30.0 сая төгрөгийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд ухаалаг дэлгэц, ухаалаг дэлгэцийн хөл худалдан авч 13.0 сая төгрөг, Говь-алтай аймгийн ЗДТГ-т ухаалаг дэлгэц, ухаалаг дэлгэцийн хөл, дууны өсгөгч, зөөврийн компьютер худалдан авч 17.0 сая төгрөг зарцуулсан байна.

- *ГБХНХЯ, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл:*

Уг төслийн зардлаас УИХ-ын даргын 178, 340 дүгээр захирамжуудаар томилолтын зардлыг холбогдох байгууллагын өөрийн санхүүжилтээр шийдвэрлэхээр заасан боловч төслийн хөрөнгөөс томилолтын зардал гаргасан, түүнчлэн төслийн 15.6 сая төгрөгийг шилэн хана, хаалт хийх зэрэг зориулалтын бус ажилд зарцуулсан.

2.9. Эдгээр зөрчил нь Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-т “энэ хуульд заасны дагуу өр үүсгэж байгаа аливаа этгээд нь зээллэгийн хөрөнгийг зориулалтын

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

дагуу үр ашигтай ашиглах, төсвийн сахилга батыг сахих” гэж заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.


2.10. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Төслүүдийн дундаж гүйцэтгэл 70 хувь


Гадаад зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд 2008–2025 оны хооронд нийт 158 төсөл бүртгэгдсэн бөгөөд үүнээс 84 төсөл хэрэгжилтийн шатанд үргэлжилж, 74 төсөл хэрэгжиж хүлээлгэн өгсөн байна.

Төслүүдийн гүйцэтгэлийн ТЕЗ-аар ангилан харуулбал:

Дүрслэл 4. Төслүүдийн явцын мэдээлэл



Дүрслэл 5. Нийт ажлын гүйцэтгэлийн дундаж хувь



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.11. Дээрх төслүүдийн төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж байгаа эсэхийг тодруулахад нийт ТАХ-ний 57.6 хувь нь хугацаагаа сунгасан байна. ТЕЗ-аар ангилан харуулбал:

Хүснэгт 7: Хугацаа сунгасан төслийн мэдээлэл

№	ТЕЗ	Нийт сунгалт хийсэн төслийн тоо	Дундаж сунгасан жил
1	БОУАӨЯ	6	4 жил
2	АҮЭБЯ	1	3 жил
3	ГБХНХЯ	4	3 жил
4	НЗДТГ	15	3 жил
5	СЯ	10	3 жил

Энэ үзүүлэлтээс харахад ТАХ дунджаар 2.2 жилээр хугацаа нь сунасан байна.

Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

6	Орхон ЗДТГ	3	3 жил
7	ЭХЯ	11	2 жил
8	ХББОСЯ	8	2 жил
9	БОУАӨЯ	2	2 жил
10	ЗГХЭГ	2	2 жил
11	ХЗДХЯ	4	2 жил
12	ЭМЯ	15	1 жил
14	ЗТЯ	7	1 жил
15	БХЯ	1	1 жил
16	ССАЖЗЯ	2	1 жил
Нийт дундаж		91	2.2 жил

шаардлага хангаагүй ТАХ-г санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.12. Хугацаа сунгасан ТАХ-г дурдвал:

СаЯ, Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл:

Уг төсөл 2018-2023 онд АХБ-ны 25.0 сая ам.долларын зээлээр хэрэгжиж байгаа ба төслийн хүрээнд баригдах шинэ дата төвийн барилгын зураг төсвийг боловсруулж, батлуулахгүйгээр зээлийн хэлэлцээрийг хийснээс 1.9 жилийн дараа зураг төсвийг боловсруулж, Барилгын хөгжлийн төв 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зураг төсвийг баталсан. Төсөл хаах хугацаа анх 2023 он байсан бөгөөд төслийн хугацааг нийтдээ 3 удаа сунгаж 2027 онд төслийн хугацаа дуусах болсон байна.

СаЯ, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл:

Уг төсөл 2016-2024 онд АХБ-ны 19.4 сая зээлжих тусгай эрх буюу 27.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ба төслийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг, Боршоо боомтуудад баригдах барилга, хатуу хучилттай авто замын зураг төсвийг боловсруулж, батлуулалгүйгээр зээлийн хэлэлцээрийг байгуулснаас 3 жилийн дараа буюу 2019 онд зураг төсвийг батлуулж 2020 онд барилгыг ажлыг эхлүүлсэн. Төслийн хаах анхны хугацаа 2022 он байсан ч 2025 онд дуусахаар 2 удаа сунгасан ба 2027 он хүртэл дахин сунгахаар хүсэлт гаргасан.

БЯ, МХТС-ийн Сургалт, Аутсорсингийн төв байгуулах төсөл:

Уг төсөл БНЭУ-ын Экспорт импорт банкны 20.0 сая ам.долларын зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа ба гүйцэтгэгчээр БНЭУ-ын П.К.Саксена Контрактор компани шалгарч 10.1 сая ам.доллороор 2020-2022 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор барилга угсралтын ажил удааширч 2025 оны 12 дугаар сарыг дуустал гэрээний хугацааг сунгасан боловч барилга угсралтын ажил 2025 оны 10 сарын байдлаар 47%-тай гүйцэтгэлтэй байна.

ХББОСЯ, “Солонго-1”, “Солонго-2” орлогод нийцсэн орон сууцны хорооллын төсөл:

Уг төсөл БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн 266.8 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 5002 айлын орон сууц барих зорилгоор хэрэгжиж байна. Зээлийн хэлэлцээрийг 2020 онд байгуулж, 40 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр баталсан. Зээлээр барилга угсралт, зураг төсөл, барилгын менежмент, зөвлөх үйлчилгээ болон төрийн албан хаагчдыг БНСУ-д сургах зардлыг санхүүжүүлнэ. Хэрэгжилтийн явцад зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгох, зураг төсөл боловсруулах, ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлууд төлөвлөснөөс 4–8 сараар удааширсан. Энэ нь Ковид-19 цар тахал, тендерийн гомдол, төсөл хэрэгжих талбай “Буянт-Ухаа” нисэх онгоцны буудлын ойролцоо байрлалтайгаас шалтгаалан ИНЕГ-аас барилгын өндөрт 9 давхрын хязгаарлалт тогтоож төлөвлөлт өөрчлөх зэрэг шалтгаанаар төслийн хугацаа сунгагдсан. Барилга угсралтын ажил 2024 оны 3 дугаар сарын 1-нд эхэлсэн бөгөөд төслийн хугацаа нь 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хүртэл сунгагдсан байна.

2.13. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр улсын хөгжлийн бодлого, зорилгод нийцсэн, ирээдүйд үр нөлөө үзүүлэх дараах төсөл, арга хэмжээ хэвийн хэрэгжиж байна. Дурдвал:

ЭХЯ, Эрдэнэбүрэнгийн 90МВт-ын усан цахилгаан станцын төсөл:

Уг төсөл нь БНХАУ-ын 908 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа ба Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумыг хамарч Ховд голын Шижигтийн хавцалд баригдах жилд дунджаар 366 сая кВт*цаг эрчим хүч үйлдвэрлэх 90МВт хүчин чадалтай.

Төслийн хүрээнд бүтээн байгуулалтад шаардлагатай дэд бүтцийн ажлыг гүйцэтгэн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Уг төсөлд шаардлагатай бараа материал, техник хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт, дотоодын ажиллах хүчний тогтвортой байдалд тусгайлан анхаарах шаардлагатай бөгөөд энэ нь төслийг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

Сая, Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл:

Уг төсөл нь АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламж 350.0 сая ам доллар МУ-ын Засгийн газрын 111.7 сая ам доллар нийт 461.7 сая ам долларын хөрөнгөөр 2021-2026 онд “Улаанбаатар хотын ус хангамжийг газрын доорх нөөцөөс урт хугацаанд, тогтвортой нэмэгдүүлж, дулааны цахилгаан станцуудад хаягдал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар дахин ашиглах дэд бүтэц бий болгон, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний институцын чадварыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зорилготой үндсэн 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлж байна. 2025 оны байдлаар Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл 96.2 хувь, Хаягдал ус дахин боловсруулах төсөл 94 хувь, Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл 90 хувийн хэрэгжилттэй байна.

АҮЭБЯ, Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл:

Уг төслийг БНЭУ-ын 1,698.2 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн (2016 онд зээлийн хэлэлцээр хийгдсэн) хүрээнд хэрэгжиж байгаа ба МУ-ын ЗГ-ын 2017 оны 92 дугаар тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэр барих төрийн өмчийн компанийг байгуулсан байна.

Төслийг нийт дараах 4 багц ажилд хуваан хэрэгжүүлж байна.

- ЕРС 01 - Технологийн бус барилга байгууламж /Байр сууц бусад иргэний барилга/, ус хангамжийн систем, талбайн дэд бүтэцийн багц. /2020 оны 2 дугаар сарын 02-ны өдөр гэрээ байгуулагдсан/ Ажлын явцын гүйцэтгэл 100 хувь байна.
- ЕРС 02 - Анхдагч процессийн болон Дагалдах байгууламжууд. /2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулагдсан/ Ажлын явцын гүйцэтгэл 52.3 хувь байна.
- ЕРС 03 - Үйлдвэрийн Дулааны цахилгаан станц. /2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулагдсан/ Ажлын явцын гүйцэтгэл 38.2 хувь байна.
- ЕРС 04 - Патенттай технологийн 7 байгууламж. /2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулагдсан/ Ажлын явцын гүйцэтгэл 8.7 хувь байна.

Төслийн нийт ажлын явц 4 багцын хүрээнд 35.2 хувь байна. Дулааны цахилгаан станц, төвөгшил ихтэй технологийн барилгын ажил нь худалдан авах ажиллагаатай холбоотой хугацааны хувьд удааширч нийт ажлын явц төлөвлөснөөс 5 хувь хоцрогдолтой байна.

Монголын талын хөрөнгө оруулалт:

2019 онд 17.5 км хүнд даацын автозам, 27 км төмөр зам, 3.7 км холбоос зам, төмөр бетон гүүр, туннел, 18 км ЦДАШ, дэд станц барьж улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

ХББОСЯ, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл:

**Нийгэм,
эдийн
засагт үр
нөлөө
бүхий
төслүүд**

Уг төсөл БНХАУ-ын Засгийн газраас 20 жилийн хугацаатай 248.6 сая, МУ-ын 13.1 сая нийт 262.7 сая ам.долларын санхүүжилтээр хэрэгжиж байна. Одоогийн байдлаар 35 төрлийн 55 байгууламжийн барилга угсралтын ажил хийгдэж дууссан, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажил 96%-тай, төслийн ерөнхий хэрэгжилт 98%-тай байна. Төслийн туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Төв цэвэрлэх байгууламж дээр ирж байгаа хаягдал усны бохирдлын хэмжээ MNS 6561:2015 стандартаас 2-3 дахин их бохирдолтой байгаа бөгөөд нэмэлт цэвэрлэгээний технологи хэрэглэх шаардлага үүссэн байна.

Төсөл, арга хэмжээний ажлын явцын зургийг Хавсралт №3-аас харна уу.

2.14. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах төсөл, арга хэмжээ үр дүн муутай, ашиглалтгүй байна. Дурдвал:

БОУАӨЯ, Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл:

Уг төсөл БНСУ-ын 14.8 сая ам.долларын хөнгөлөлттэй 40 жилийн хугацаатай, жилийн 0.15%-ийн хүүтэй нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байна.

Байгаль орчны төв лабораторийн барилгын талбайд Улаанбаатар хотын 27 дугаар нэгж хорооллын замын чиг давхацсан байгаа тул шинэ лабораторийн барилгын зураг төсөл боловсруулах архитектур төлөвлөлтийн даалгаврыг Улаанбаатар хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан батлуулах шаардлага үүсэж, хүсэлт хүргүүлснээс хойш 3 сарын дараа 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр нийслэлийн Ерөнхий архитектораар батлуулж гүйцэтгэгч талд хүргүүлсэн. Монгол улсын Засгийн газраас хариуцан гүйцэтгэх ёстой лабораторийн барилга шинээр барих газрын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, холбооны гадна шугам сүлжээний зураг, төсвийн ажилд 150.0 сая төгрөг, гадна шугам сүлжээний холболтын ажилд 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2025 оны улсын төсөвт тусгуулах санал хүргүүлсэн боловч батлагдаагүй. Гүйцэтгэгч сонгон шалгаруулалтын тендерийг 5 удаа зарлаад амжилтгүй болсон. Төслийн нэгж одоог хүртэл байгуулагдаагүй.

ЭХЯ, 10 Аймгийн төвийн дулааны станц барих төсөл:

Уг төслийн хүрээнд нийт 3 багц ажил хэрэгжүүлсэн бөгөөд Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дундговь, Төв аймагт 2022 онд гэрээг байгуулан барилга угсралтыг эхлүүлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 3 багц ажил 45.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Харин Архангай аймгийн дулааны станцын сонгон шалгаруулалт амжилтгүй болж хэрэгжээгүй байна. Төслийн төлөвлөлтийн шатанд нарийвчилсан судалгаа, тооцоолол, ТЭЗҮ, зураг төсөв байхгүйгээс төслийн ажлын явц удааширч, үнийн өсөлтөөс хамаарч үргэлжлүүлэх боломжгүй болсон байна.

ССАЖЗЯ, Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл:

Уг төслийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын нутагт байрлах Дэлүүн Болдог байгалийн дурсгалт газрын мэдээллийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэгч Мандал констракшн ХХК нь тухайн ажлын сонгон шалгаруулалтад оролцохдоо сонгон шалгаруулалтын баримт бичгийг хуурамчаар үйлдсэн болох мэдээллийн үндсэн дээр АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст шалгагдаж байгаагаас ажил нь удааширсан.

ХББОСЯ, Замын-Үүдийн дэд бүтэц сайжруулах төслийн багц 2, “Усан хангамж, ариутгах татуурга”:

“Ундны ус цэвэршүүлэх үйлдвэр”-ийг 2009-2016 онд хэрэгжүүлсэн ч 2021 онд Замын-Үүд дулааны станц байгуулагдаж тус үйлдвэрийг хүлээн авсан байна. Тус үйлдвэр нь хоногт 3250м³ ус цэвэршүүлэх хүчин чадалтай ба удаан хугацааны буруу хадгалалтын явцад ус цэвэршүүлэх зориулалттай эсрэг осмосын төхөөрөмжийн шүүлтүүрүүд ашиглалтын шаардлага хангахгүй болсон. Мөн хянах хэмжих хэрэгслүүд хөлдөж хагарч гэмтэн зэвэрч муудсан байна. Тус үйлдвэрийг

Гүйцэтгэл
хангалтгүй
төслүүд

ашиглахад засвар үйлчилгээ, ашиглалтын зардал өндөр тул ашиглах боломжгүй болсон байна.

ХББОСЯ, Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төсөл:

2008 онд МУ-ын ЗГ болон БНФУ-ын Засгийн газар хоорондын 9,535,000 евро 39,570.0 сая төгрөгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд Хонгт 24000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай 18 байгууламжаас бүрдсэн цэвэрлэх байгууламжийн өргөтгөл барих төсөл 2016 онд эхэлсэн боловч 2025 оны 9 дүгээр сарын байдлаар ашиглалтад ороогүй, ашиглах байгууллага тодорхойгүй, зээлээр бий болсон барилга байгууламжийг ашиглах талаар үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

СаЯ:

Тус яаманд бүртгэгдсэн 3.1 их наяд төгрөгийн 41 буцалтгүй тусламжийн ТАХ байна. 165.5 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий сургууль, эмнэлэг, нисэх онгоцны буудлын барилга баригдсан байна. Харин тухайн төслүүдэд эдийн засгийн тооцоолол, төсөвт суух урсгал зардлын тооцоо зэрэг хийгдээгүй, ашиглалт хангалтгүй барилгууд төрийн өмчид нэмэгдэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-дах заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

ЗТЯ, Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл:

Уг төслийг 12.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэсэн ч үр ашиг, эдийн засгийн тооцоо хийгээгүйгээс төсөвт (урсгал зардал) ачаалал үүсгэж байна.

НЗДТГ: Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төсөл:

Уг Төслийн хүрээнд 2022-2026 онд Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрийн 4 байршилд нүхэн гарц барихаар төлөвлөсөн ч өнөөдрийн байдлаар таван шарын төмөр замын гармын баруун талын нүхэн гарц (Толгойт-Улаан баатар хоорондын төмөр замын 396-р км ПК9 үе 36 зв-д байрлах авто машины нүхэн гарц) баригдаж, бусад 3 нүхэн гарцын ажил эхлээгүй удааширсан байна. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл удааширсантай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Таван шарын төмөр замын гармын баруун тал, Геологийн төв лабораторийн уулзваруудад хийх нүхэн гарцын зураг төсөв 2023 оны 6 дугаар сард батлагдсан, Гермес төвийн урд, төмөр замын зоорины урд нүхэн гарц, Нарны зам болон Их хүрээний гудамжны уулзварын нүхэн гарцуудын зураг төсөв батлагдаагүй;
- Нүхэн гарц хийх 3 байршлын газар чөлөөлөлтийн ажил эхлээгүй, зарим газруудад газар чөлөөлөлтийн ажил дуусаагүй;
- Холбогдох техникийн нөхцөлийг аваагүй;
- Нүхэн гарцыг дагаж хийгдэх авто болон явган зорчигчийн гарцын зураг, борооны ус зайлуулах системийн зураг хийгдээгүй;
- Төслийн хэрэгжилт удааширснаас шалтгаалж БНХАУ-ын Эксим банкны зүгээс санхүүжилтээ зогсоохыг урьдчилсан байдлаар мэдэгдсэнээс санхүүжилтгүй зогсох эрсдэл үүссэн байна.

Төсөл, арга хэмжээний ажлын явцын зургийг Хавсралт №3-аас харна уу.

2.15. Сангийн сайд 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 10.8-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 10.7-д заасан тайланг нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор багтаан хүргүүлнэ.” гэж заасны дагуу Сангийн яам 2024 онд хэрэгжсэн нийт 71 төслөөс 65 төслийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг нэгтгэн санал, зөвлөмж боловсруулсан байна.

2.16. Энэ санал, зөвлөмжийн мөрөөр хэрхэн арга хэмжээ авсныг тооцож үнэлээгүй байна.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

2.17. Өрийн удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4-д заасны дагуу СаЯ Засгийн газрын гадаад өрийн мэдээллийн ил тод байдлыг хангах бөгөөд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан дараах мэдээллийг ил тод мэдээлэхээр тусгасан байна. Үүнд:

- Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг улирал тутам олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх,
- Засгийн газар болон орон нутгийн зээллэг, өр төлбөр, Засгийн газрын өрийн баталгаа, болзошгүй өр төлбөр нийтэд ил тод байх,
- Монгол Улсын Засгийн газраас гадаад улс, олон улсын байгууллага болон банк, санхүүгийн байгууллагаас зээл авах аливаа гэрээ, хэлэлцээр хийх, үзэглэх, батлах, соёрхон батлах үйл явцыг тухай бүр нийтэд ил тод мэдээлэх,
- Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээл авах, зээлийн гэрээ, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах бүрд зээлийн нийт хэмжээ, эргэн төлөх хуваарь, хүү, зээлийн зориулалт зэргийг тухай бүр нийтэд мэдээлэх.

2.18. СаЯ дараах мэдээллийг ил тод мэдээлж байна. Үүнд:

- ЗГ-ын өрийн статистикийн товхимлыг 2021-2025 онуудад улирал бүр,
- ЗГ-ын дунд хугацааны өрийн удирдлагын стратеги.

2.19. Эдгээр мэдээлэл нь хуульд заасан ил тод мэдээлэх дээрх мэдээллүүдийг бүрэн хамруулаагүй байна.

2.20. Сангийн сайд 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 13 дугаар зүйлийн 13.3⁹, 13.12¹⁰ -т СаЯ нь гадаад зээлийн ТАХ-ний мэдээллийг цахим системд байршуулж олон нийтэд хүргэхээр тусгасан ч зарим ТАХ-ний төлөвлөлт, төсөвлөлт, ашиглалт, бүртгэл, санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хяналт, үнэлгээ, тайлагналын мэдээллийг Удирдлагын мэдээллийн систем /odamis.mof.gov.mn/-д бүрэн байршуулаагүй байна. Тухайлбал:

ХББОСЯ:

- Дэд бүтцийн хөгжил – Сонгинохайрхан төсөл
- Дэд бүтцийн хөгжил – Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл

ХЗДХЯ:

- Хууль сахиулах их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн төв байрны сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл

ГБХНХЯ:

- Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

ЭХЯ:

- Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл -2
- Сайншанд-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 204,6 км урт ЦДАШ, 220/35 кВ-ын “Цагаансуварга”, 220/110/35 кВ-ын “Сайншанд” дэд станцуудын өргөтгөл барих төсөл
- Багануур-Чойрын 220 кВ-ын 188 км урттай 2 хэлхээт ЦДАШ, 220/110/35 кВ-ын Багануур, Чойр дэд станцуудын өргөтгөл
- Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 287км урт ЦДАШ

⁹ 13.3.Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төсөл хэрэгжүүлэх нэгж нь энэ журмын 13.2-т заасны дагуу гадаад зээлийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, ашиглалт, бүртгэл, санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хяналт, үнэлгээ, тайлагналыг тухай бүр цахим системээр дамжуулан гүйцэтгэж, ил тод байдлыг хангах бөгөөд мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

¹⁰ 13.12. “Цахим системийн мэдээллийг /odamis.mof.gov.mn/, /publicinvestment.gov.mn/ цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ”

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

- Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төсөл (Эрдэнэбүрэн-Мянгад эрчим хүчний ЦДАШ)
- Эрчим хүчний төсөл-2
- Эрчим хүчний төсөл-2 -тусламж
- Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл
- Дулааны гуравдугаар цахилгаан станц өргөтгөх төсөл
- Байдрагийн усан цахилгаан станц барих төсөл

ЗТЯ:

- Монгол Улсын тээврийн холболт ба логиستيкийг сайжруулах төсөл
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төсөл
- Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км автозам барих төсөл
- Улаанбаатар хот – Шинэ Хархорум хот чиглэлийн 291.3 км автозамыг 4 эгнээ болгон өргөтгөн, шинэчлэх төсөл

АҮЭБЯ:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх төсөл

ССАЖЗЯ :

- Үндэсний урлагийн их театрын барилга барих төсөл

2.21. Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 11.12-т “Төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөл, арга хэмжээний тайлан, мэдээ холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тухай бүр оруулна” гэж заасантай холбогдуулан нийт 51 төслийн нэгжийн шилэн дансанд мэдээллийг тулган үзэхэд дараах байдалтай байна.

- 45 төслийн нэгж 2025 оны III улирлын байдлаар нийт 5,805 мэдээлэл оруулах ёстойгоос 5,625 мэдээллийг оруулсан байна. Үүнээс хугацаа хэтэрсэн мэдээлэл 139, огт оруулаагүй мэдээлэл 180 байна.
- 6 төслийн нэгж шилэн данс нээж ажиллаагүй байна.

Эдгээр төслийн нэгжийн шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийн гүйцэтгэлийн хувийг авч үзвэл 97 хувьтай байна.

Гадаад зээл, тусламжийн үр дүнд нийгэм, эдийн засагт эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байна

2.22. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцож, үнэлэхийг хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна.

Өрийн удирдлагын тухай хууль

- Засгийн газар болон орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр нөлөө нь ирээдүйд өрийн дарамт учруулахгүй байх

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь төсөл хэрэгжиж дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг хийж цахим системээр тайлагнана
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөл хэрэгжиж дууссанаас хойш хоёр жилийн дараа төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээ хийж, тайланг цахим системд оруулна

Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам

- Төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээг хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулах.

2.23. Гэсэн хэдий ч хэрэгжүүлсэн 74 ТАХ-ний 71 ТАХ-ний үр нөлөөг холбогдох байгууллагууд тооцож, үнэлээгүй байна.

2.24. Дараах 3 ТАХ-ний үр нөлөөг тооцож үнэлсэн байна. Үүнд:

“Эрчим хүч – 2” төсөл:

Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ, Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн харьяа Багануур дүүрэг, 10 аймгийн төв, бүх сумын төвийн түгээх сүлжээний техникийн шинэчлэлийн ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгчээ. Тухайн төслийн хүрээнд хуучирч ашиглалтаас гарсан тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулах шугамыг өргөтгөж шинэчилснээр, шинээр хэрэглэгч холбох, хэрэглэгчдийг аюулгүй, найдвартай, стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах боломжтой болсон. Мөн Ховд аймгийн Мянгад суманд 10 МВт-ын нарны цахилгаан станц барьж ашиглалтад оруулснаар 2022-2024 оны хооронд 57.9 сая.кВт.ц цахилгаан эрчим хүчийг ББЭХС-д нийлүүлж мөн хэмжээгээр импортоор авах эрчим хүчний биет хэмжээг бууруулсан байна.

Тус төслийн хүрээнд ЭБЦТС ТӨХК-ийн техникийн алдагдал 1.3 хувиар, нийт алдагдал 3 хувиар, БЗӨБЦТС ТӨХК-ийн техникийн алдагдал 0.8 хувиар, нийт алдагдал 2.7 хувиар тус тус буурсан бол 14 аймгийн хэмжээнд нийт 69,279 ширхэг ухаалаг тоолуур байршуулсан нь тухайн түгээх компаниудын арилжааны болон зүй бус алдагдлыг бууруулахад томоохон түлхэц болсон байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төсөл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн 6 төвийг Архангай, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Ховд, Хөвсгөл аймагт барилга угсралтын ажлыг явуулж 5 аймгийн хөгжлийн төвийн барилгыг 2023 онд улсын комисст хүлээлгэн өгч, Архангай аймгийн хөгжлийн төвийн барилгыг 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн үр дүнгийн хувьд 2025 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар нийт 241 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээ хийж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд хамруулж байна. Үүнээс хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр шууд ажиллах боломжтой 7 хүнд зөвлөгөө мэдээлэл өгч ажлын байранд зуучилж, хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

“Түлэнхийн төв барих” төсөл:

Барилгыг 2023 онд ашиглалтад оруулж, 45 нэр төрлийн 548 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангасан байна. Түлэнхийн төв эмнэлэг ашиглалтад орсноор хуучин ашиглаж байсан Түлэнхийн салбар эмнэлгийн 70 ор дээр эрчимт эмчилгээний 10 ор, нөхөн сэргээх мэс заслын 20 ор, сэргээн засах эмчилгээний 20 ор, ясны эмэг, мэс заслын 40 ор, соготг гэмтлийн 40 ор (нийт 130 ор) шинээр нэмэгдэж 2 төв нийт 600 ортойгоор үйл ажиллагаа явуулах эмнэлгийн орны хүчин чадал 27.7%-иар нэмэгдсэн байна.

2.25. ТЕЗ-ийн хэрэгжүүлэн дууссан 41 ТАХ-ээс 39 ТАХ-ний үр дүн, нөлөөллийг тооцсон хаалтын тайланг гаргалгүйгээр төслийг татан буулгасан нь Засгийн газрын “Гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.10¹¹-д заасан шаардлагыг хангаж ажиллаагүй байна. Энэ асуудалд ТЕЗ нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.26. ТАХ-ний үр дүн, нөлөөллийг тооцсон хаалтын тайланг гаргалгүйгээр төслийг татан буулгасан жишээг дурдвал:

¹¹ Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төсөл, арга хэмжээний үр дүнгийн үнэлгээг уг төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусахаас нэг сарын өмнө хийж цахим системд тайлагнах ба төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь төсөл хэрэгжиж дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг хийж цахим системээр тайлагнана.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

ЗТЯ:

- Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км автозам барих төсөл,
- Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл

ГБХНХЯ:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
- Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2,
- Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл

АҮЭБЯ:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх төсөл

БХЯ:

- Цэргийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл

Монгол Улсын Шадар сайд /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/:

- Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл
- Онцгой байдлын албаны гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл
- Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл
- Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт II шатны эмнэлгийн төсөл
- "Зудын гамшгийн хариу арга хэмжээний төсөл"

СаЯ:

- Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл
- Тогтвортой амьжиргаа-3 төсөл
- Монгол Улс дахь Засаглалыг бэхжүүлэх төсөл
- Төлбөрийн системийн шинэчлэл төсөл

ХББОСЯ:

- "Тайшир-Алтай ус хангамжийн" төсөл
- "Дэд Бүтцийн Хөгжил-Сонгинохайрхан" төсөл
- "Дэд Бүтцийн Хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ " төсөл
- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл
- Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл
- Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн төсөл

ХЗДХЯ:

- "Хууль сахиулах их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн төв байрны сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл"
- "Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"

Гадаад зээл  Өрийн дарамт	Гадаад зээлийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг бодитой тооцоо, дүн шинжилгээнд үндэслэн тооцоолоогүй байна.
--	---

2.27. Гадаад зээлийн хөрөнгөөр 2008 – 2025 оны хооронд хэрэгжүүлж байгаа 116 ТАХ-ний эргэн төлөлтийн мэдээллийг харуулбал:

Хүснэгт 8: Зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл /сая төгрөг/

ТЕЗ	Нийт зээлийн гэрээний дүн	Эргэн төлөлтийн нийт дүн	Эргэн төлөлт хийсэн төслийн тоо
БОУАӨЯ	53,233.2	-	1
БХЯ	33,159.5	244.2	1
АҮЭБЯ	6,091,681.0	64,747.8	1
ЗГХЭГ	61,749.0	2,831.6	1

Энэ үзүүлэлтээс харахад нийт зээлийн 1.8 хувийг эргэн төлсөн байна.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

ССАЖЗЯ	136,311.3	1,711.1	2
ХЗДХЯ	141,692.0	14.5	3
ЦХИХХЯ	219,543.9	408.1	2
Орхон ЗДТГ	62,414.4	591.3	2
ШСАА	516,102.9	234.2	4
ЭЗХЯ	692,676.7	1,834.8	4
ГБХНХЯ	596,893.8	27,549.8	5
БоЯ	642,467.3	35,462.2	7
ЗТЯ	4,022,999.0	101,378.4	9
СаЯ	916,564.5	31,000.1	9
ЭХЯ	2,931,843.0	29,804.8	11
ЭМЯ	1,512,845.0	20,074.7	12
ХББОСЯ	2,351,040.0	30,778.5	11
НЗДТГ	3,050,567.0	84,901.8	20
Нийт дүн	24,033,784.1	433,567.9	105

Эх сурвалж: Сангийн яам

2.28. СаЯ-нд бүртгэлтэй эргэн төлөлт хийж байгаа нийт гадаад зээлийн (төслийн болон хөтөлбөрийн) эргэн төлөлтийн мэдээллийг харуулбал:

Хүснэгт 9: Нийт гадаадын зээлийн эргэн төлөлт, ханшийн зөрүү /сая төгрөг/

Он	Зээлийн эргэн төлөлтийн дүн		Ханшийн зөрүү
	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	
2025	1,112,467.1	435,707.3	1,718,512.8
2024	1,232,935.9	558,402.4	(602,060.2)
2023	951,409.1	434,512.5	242,162.8

2025 онд ханшийн алдагдал 1.7 их наяд төгрөгт хүрсэн байна

Эх сурвалж: Сангийн яам

2.29. Дээрх үзүүлэлтээс харахад гадаад зээлийн эргэн төлөлтөд жилд дунджаар үндсэн төлбөр 1.1 их наяд төгрөг, зээлийн хүүд 476.2 тэрбум төгрөг төлсөн байна.

2.30. Нийт гадаад зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн 2026 – 2040 оны хуваарийн мэдээллээс харахад дунджаар зээлийн үндсэн төлбөрт 1.7 их наяд төгрөг, зээлийн хүүд 389.6 тэрбум төгрөг төлөхөөр¹² байна.

2.31. Гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнтэй харьцуулахад дунджаар 6.2 хувийг эзэлж байна. Харьцуулан харуулбал:

Хүснэгт 10: Гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын харьцаа /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2026 он	2027 он	2028 он
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	32,980.0	34,626.0	37,829.2
Гадаад зээлийн үндсэн төлбөр	1,529.8	1,662.0	1,753.2
Гадаад зээлийн хүүгийн төлбөр	554.0	554.9	573.8
Гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь	6.3	6.4	6.1

Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл, гадаад зээлийн эргэн төлөлтийн хуваарь

¹² Зээлийн эргэн төлөлтийн хуваариас харахад 2035 оноос хойш зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

2.32. Гадаад зээлийн эргэн төлөлт төсөвт ачаалал үзүүлж байгаа эсэх талаар бодитой тооцоо, судалгаа байхгүй байна.

2.33. Засгийн газрын гадаад зээлийн 55 хувь нь ам.доллар, 21 хувь нь зээлжих тусгай эрх, 13.4 хувь нь иен, 6 хувь нь евро, 4.6 хувь нь бусад валютаас бүрдсэн байна. Энэ нь ханшийн эрсдэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Тухайлбал:

Гадаад валютын эсрэг төгрөгийн ханш сулрахад дараах эрсдэлүүд бий болж болзошгүй байна. Үүнд:

- *Гадаад валютын эсрэг төгрөгийн ханш 5.0 хувь сулрахад өрийн шалгуур үзүүлэлт 2026 онд зөрчигдөхгүй, 2027 онд 1.4, 2028 онд 3.8 хувиар, 10.0 хувь сулрахад өрийн шалгуур үзүүлэлт 2026 онд зөрчигдөхгүй, 2027 онд 6.0, 2028 онд 11.1 хувиар, 15 хувь сулрахад өрийн шалгуур үзүүлэлт 2026 онд зөрчигдөхгүй, 2027 онд 10.7, 2028 онд 19.1 хувиар тус тус Засгийн газрын өрийн 2026-2028 онд баримтлах стратегийн баримт бичигт заасан өрийн хязгаар зөрчигдөх,*
- *Гадаад зээлийн 2025.09.30-ны өдрийн жилийн эцсийн үлдэгдэл өөрчлөгдөхгүй гэж үзвэл гадаад валютын эсрэг төгрөгийн ханш жил бүр 5.0 хувь сулрахад гадаад зээлийн үлдэгдэл 2026-2028 онд 1,158.6-1,277.3 тэрбум, 10.0 хувь сулрахад 2026-2028 онд 2,317.1-2,806.6 тэрбум, 15.0 хувь сулрахад 3,475.6-4,596.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэх,*
- *Гадаад валютын эсрэг төгрөгийн ханш 5.0 хувь сулрахад өрийн үйлчилгээний зардал¹³ 2026-2028 оны хооронд 706.5 тэрбум, 10.0 хувь сулрахад 1,461.3 тэрбум төгрөгийн бодит ханшийн алдагдал хүлээх зэрэг эрсдэлтэй байна.*

2.34. Гадаад зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3 хувь байгаа боловч өрийн зардал ханшийн өөрчлөлтөөр өсөх эрсдэлтэй бөгөөд гадаад зээлийн дундаж хугацаа 7.5 жил байгаа тул дахин санхүүжигдэх эрсдэл харьцангуй бага байна.

2.35. Гадаад зээлийн хэрэгцээ, шаардлага, зохистой хэмжээ, улсын төсөвт үзүүлэх үр нөлөө, салбар, салбар дундын болон нэгдсэн зохион байгуулалт хангалтгүй байгаа нь гадаад зээлийн талаар нэгдсэн бодлогыг тодорхойлж мөрдүүлэх шаардлагатайг харуулж байна. Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох талаар УИХ-ын бүрэн эрхэд тусгасан ч хэрэгжихгүй байна.

2.36. Өмнөх аудитаар Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох асуудлыг УИХ-д толилуулж, МУ-ын Ерөнхий сайдад зөвлөмж өгсөн ч хэрэгжээгүй байна.

2.37. Мөн өмнөх аудитаар МУ-ын Ерөнхий сайд болон Сангийн сайдад нийт 11 зөвлөмж өгснийг Сангийн яамнаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03/9032 албан бичгээр тус 11 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлснээр тайлагнан ирүүлсэн ч зарим зөвлөмж хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Төгрөгийн ханш сулрах нөхцөлийг бууруулах иж бүрэн хөтөлбөр байхгүй,
- Гадаад зээлээр санхүүжүүлэх 30 тэрбум төгрөгөөс доош өртөгтэй төсөл, арга хэмжээг сонгох, төсөвт өртгийг тооцох, үнэлэх, эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн нөлөөллийг тооцох аргачлалыг батлаагүй,
- Хөгжлийн бодлого зорилготой уялдаагүй, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй ТАХ-нд төсөв хуваарилсан.

¹³ Жил бүр өөрчлөгдөнө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл, арга хэмжээ улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан бодлого, зорилгод бүрэн чиглээгүй, дийлэнх нь тэргүүлэх ач холбогдол бүхий, нийгэм, эдийн засагт үр нөлөөтэй эсэх нь судалгаа, тооцоонд үндэслэн бодитой тогтоогоогүй гэрээ хэлэлцээрт орж Улсын Их Хурлаар соёрхон батлагдаж байна.
2. Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох журамд заасан шалгуур, шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төслийн хугацаа удаашрах зэрэг эрсдэлийг нэмэгдүүлж, төсөвт ачаалал үүсгэж байна.
3. Гэрээ хэлэлцээр нь хийгдэж, Улсын Их Хурлаас соёрхон баталсан гадаадын зээлийн нийт 89 төслийн 14.7 их наяд төгрөг ашиглалтгүй байгаа нь тухайн төслийн хүлээгдэж буй үр дүн гарахгүй удаашрах, эдийн засгийн өсөлтийг дэмжих зардлын хэмжээ буурах эрсдэлийг дагуулж, зээлийн хөрөнгийг ашиглалтын чиглэлээр бодлогын томоохон өөрчлөлт хийх шаардлагатайг харуулж байгаа бөгөөд зээлийн ашиглаагүй үлдэгдэлд жил бүр хөрөнгө баталгаажуулсны хураамж төлж үргүй зардал гаргаж байна.
4. Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлоогүйгээс гадаад зээлийн зохистой харьцаа, хязгаарлалт байхгүй, нэгдсэн зохион байгуулалтгүйгээс гадаад зээлийн хөрөнгийг улсын тэргүүлэх чиглэл бус, үр нөлөө багатай зарим арга хэмжээнд зарцуулсан байна.
5. Гадаадын зээл, тусламжийн талаарх мэдээлэл нь холбогдох мэдээллийн нэгдсэн систем, цахим хуудаст иж бүрэн бус, хэрэгжүүлэгч байгууллагуудад харилцан уялдаа холбоогүй, нэгдсэн зохион байгуулалтгүй ажиллаж байна.
6. Гадаад зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийт 158 төсөл арга хэмжээнд 11.0 их наяд төгрөг зарцуулсан боловч нийгэм, эдийн засагт ямар бодит үр нөлөө гарсныг тооцож үнэлээгүй, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг олон нийтэд тодорхой, ил тод мэдээлээгүй байна.
7. Гадаад зээлийн эргэн төлөлт улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг бодит судалгаа, дүн шинжилгээ хийн тооцохгүй байгаагаас ирээдүйд өрийн дарамт бий болох эрсдэлтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хуралд толилуулах нь:

- Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан эсэхийг холбогдох байгууллагын санал, дүгнэлтэд үндэслэн гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн талаар баримтлах бодлогыг боловсруулан батлуулах.
- Гадаад төслийн зээлийн ашиглалтыг олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу цаг хугацаанд нь үр ашигтай дуусгахад чиглэсэн байдлаар улсын төсөвт тусгах талаар тодорхой бодлогын шинэчлэл хийх.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд:

- Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох журамд заасны дагуу үнэлгээ хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох санал, дүгнэлтийг гаргах.

Сангийн сайдад:

- Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасан санал, дүгнэлтийг бодит тооцоо, судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн гаргах.
- Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд нэгдсэн төслийн удирдах хороо байгуулах ажлыг зохион байгуулж, цаашид урсгал зардал гаргах аливаа нэгж бий болгохгүй байх.
- Гадаад зээл, тусламжийн явц, үр дүн болон бий болсон үр нөлөөг улсын хэмжээнд нэгтгэн гаргах.
- Гадаад зээлийн эргэн төлөлт улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг бодит судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн хийж, ирээдүйд өрийн дарамт бий болох эрсдэлийг удирдах.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг бусад ТЕЗ-тай харилцан уялдаатай солилцож, мэдээллийн системд иж бүрэн, үнэн зөв байршуулах.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд ил тод мэдээлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хууль, журамд заасан шалгуур, шаардлагыг хангасан байдлаар боловсруулах, шаардлага хангаагүй тохиолдолд ажил эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байх.
- Төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд чанартай гүйцэтгүүлэхэд үе шатны хяналтыг тогтмол хэрэгжүүлж, гэрээний хугацааг сунгахгүй байх.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

- Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг холбогдох журамд заасан хугацаанд хийж цахим системээр тайлагнах.
- Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг хууль тогтоомжийн дагуу гаргаж Сангийн яамтай тулган баталгаажуулан, харилцан уялдаатай ажиллах.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Сангийн яамнаас ирүүлсэн санал


МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025.12.17 № 02141022
танай 2025.12.15-ны № 07/3543 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

